



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 8153

Улаанбаатар хот

Г

Г

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны багцын XVII.1.1.3 Аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга /Хэнтий, Хэрлэн сум/ угсралтын ажлын гүйцэтгэгч "Хар чонот" ХХК-ны 6,314,800,000 (зургаан тэрбум гурван зуун арван дөрвөн сая найман зуун мянган) төгрөгийн төсвийг захиран зарцуулах, гэрээг шинэчлэн байгуулах, сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах, эрхийг Хэнтий аймгийн Засаг дарга /Ж.Оюунбаатар/-д шилжүүлсүгэй.

2. Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 198 дугаар тушаалд заасны дагуу төсвийг захиран зарцуулах, техникийн хяналт тавих эрх болон бусад эрх хэвээр хадгалагдана.

3. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Баярсайхан/-д даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080545